



ИХ, ДЭЭД БОЛОН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН  
БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД ГАМШГААС ХАМГААЛАХ БОЛОН ГАЛЫНАЮУЛГҮЙ  
БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ, СТАНДАРТ, НОРМ, НОРМАТИВЫН БАРИМТ БИЧГИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХАА ТӨЛӨВЛӨГӨӨТ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ  
ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

#### Нэг. Хяналт шалгалтын зорилго

Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх серег нелөөллийг бууруулах тухай хууль тогтоомж хууль тогтоомж, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Их, дээд болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн барилга, байгууламжид зохион байгуулж, болзошгүй эрсдэлийг бууруулахад оршино.

#### Хоёр. Ерөнхий зүйл

2.1. Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Териин хяналт шалгалтын тухай хууль, гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, гал түймрийн улсын хяналтын дүрэм, боловсрол, соёл, шинжлэх ухаан, урлагийн байгууллагын галын аюулгүйн дүрэм, бусад галын аюулгүй байдлын норм нормативын баримт бичиг нь уг шалгалтыг явуулах эрх зүйн үндэс болно.

2.2. Хяналт шалгалтад оролцох бүрэлдэхүүн дээрх хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичиг болон энэхүү удирдамжийг баримтлан ажиллана.

2.3. Хяналт шалгалтыг зохион байгуулах явцдаа Коронавируст цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас гаргасан тогтоол, шийдвэр, Улсын онцгой комисс, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас тавьж байгаа заавар, зөвлөмж, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөх.

2.4. Хяналт шалгалтыг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/235 дугаар тушаалаар баталсан "Боловсролын байгууллагын галын аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас"-вар хяналт шалгалтыг зохион байгуулж, дүнг зөрчилтэй айл өрх тус бүрээр удирдамжийн 3.5-д заасан хаягаар цахим хэлбэрээр ирүүлнэ.

2.5. Их, дээд болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн барилга барилга байгууламжуудад хяналт шалгалтыг зохион байгуулна.

2.6. Гамшигаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагчид нь хууль тогтоомж, дүрмээр олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалтыг гүйцэтгэж, илэрсэн зөрчлийг арилгуулах, гүйцэтгэлийн хяналт шалгалтаар зөрчил арилаагүй тохиолдолд Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл ноогдуулах, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.12.10 дахь хэсэгт заасан заалтыг хэрэгжүүлнэ.

2.7. Хяналт шалгалт хийсэн тухай мэдээллийг улсын хяналтын байцаагчийн өдөр тутмын ажлын мэдээний цахим буртгэлийн программын мэдээллийн санд нэг бүрчлэн оруулсан байна.

#### **Гурав. Хяналт шалгалт явуулах хугацаа, зардал**

3.1. Хяналт шалгалтын нийслэлийн ажлын хэсгийг онцгой байдлын ерөнхий газрын мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн нар, орон нутгийн ажлын хэсгийг Онцгой байдлын газар, хэлтсийн дарга томилон удирдлагаар хангаж, гамшигаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагч нар зохион байгуулна.

3.2. Томоохон их, дээд сургууль цэцэрлэгүүдэд хяналт шалгалтыг хийхдээ 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг тушаалаар томилон ажиллуулна.

3.3. Хяналт шалгалт явуулахад шаардлагатай зардлыг тухайн орон нутгийн Онцгой байдлын байгууллага хариуцна.

3.4. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2021 оны 08 дугаар сарын 10-ны өдрөөс 08 дугаар сарын 25-ны өдрийн хооронд, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 09 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд тус тус явуулна.

3.5. Төлөвлөгөөт хяналт шалгалтын дун, мэдээг 2021 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн дотор, гүйцэтгэлийн хяналт шалгалтын дун, мэдээг 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн [Hyanahtiinheltes.obez@yahoo.com](mailto:Hyanahtiinheltes.obez@yahoo.com), Гамшигийн шуурхай удирдлагын газрын [b.myagmarsuren@petra.gov.mn](mailto:b.myagmarsuren@petra.gov.mn) цахим хаягаар тус тус зөрчлийг фото зургаар баримтжуулан илтгэх хуудсын хамт ирүүлна.

#### **Дөрөв. Хяналт шалгалтын үр дүн, авах арга хэмжээ**

4.1. Хяналт шалгалтын талаарх мэдээлэл, зөвлөмж, зааварчилгыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын вэб хуудсанд байршуулж олон нийтэд хүргэнэ.

4.2. Онцгой байдлын ерөнхий газраас хяналт шалгалтын дун, санал дүгнэлтийн талаарх танилцуулгыг шалгалтад хамрагдсан байгууллагуудын харьяалах төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шат дараатай авч хэрэгжүүлнэ.

4.3. Төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын дунг Гал түймэртэй тэмцэх газар нэгтгэн дүгнэж, Монгол Улсын Шадар сайд болон Онцгой байдлын ерөнхий газрын дарга бөгөөд гал түймрийн улсын хяналтын ерөнхий байцаагчид танилцуулж, холбогдох яам, агентлаг, газрын дарга наарт гал түймрийн улсын хяналтын ерөнхий байцаагчийн танилцуулга, мэдэгдэл, заавал биелүүлэх албан шаардлага хүргүүлэн биелэлтийг хангуулна.